



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар A/187

Арвайхээр сум

Газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн A/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг, Залууучууд-3 гудамж, 306 тоотод байрлах Даваадоржийн Буянбаярын (ЙП75080516) эзэмшил 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 1531м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц, 13 дугаар баг, П.Лувсандорж-2 гудамж, 205 тоотод байрлах Энхсайханы Баярсайханы (ЙМ93100910) эзэмшил 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 1250м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц, 5 дугаар баг, Б.Ренчинпэлжээ-1 гудамж, 109 тоотод байрлах Агийн Төмөрхуягийн (ЙЭ50071115) эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 803м² газрын зориулалтыг 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН



6224 11 0386